



## БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,  
Утас/Факс: (976) 7042-2954  
E-mail: bayanulgii@audit.gov.mn

АЙМГИЙН МОНГОЛ АРДЫН  
ХУВЬСГАЛТ НАМЫН ДАРГА  
Б.АЙБЕК ТАНАА

доо. 07.31 № 517  
танай -ны № -т

### Хандивын тайлангийн дүгнэлт

Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох Монгол Ардын Хувьсгалт намаас ирүүлсэн хандивын тайланг Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хянан баталгаажуулж, дүгнэлт гаргалаа.

#### Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгуульд оролцох Монгол Ардын Хувьсгалт нам нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.3.6, 25.4.6-д заасны дагуу иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандивын тайлангаа мөн хуулийн 37 дугаар зүйлийн 37.7-д заасны дагуу Төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагад хүргүүлж, дүгнэлт гаргуулах үүргийг хүлээнэ.

Хандивыг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, мөн хуулийн 16 дугаар зүйл, Сангийн сайдын 2017 оны 386 дугаар тушаалаар батлагдсан санхүүгийн тайлангийн маягт, зааврын дагуу бэлтгэсэн санхүүгийн тайландаа тусгах үүргийг улс төрийн нам хүлээнэ.

Аймаг дахь Төрийн аудитын газар нь Төрийн аудитын тухай хууль болон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуульд заасны дагуу сонгуульд оролцох улс төрийн нам, эвсэлд иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандивын тайланг хянан баталгаажуулж, дүгнэлт гаргана.

Намаас дүгнэлт гаргуулахаар ирүүлсэн хандивын тайланд тусгагдаагүй хандивыг хянан баталгаажулахгүй бөгөөд түүнээс үүсэх үр дагавар, хариуцлагыг Төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллага хүлээхгүй болно.

#### Дүгнэлтийн үндэслэл

Аймаг дахь төрийн аудитын газар Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох Монгол Ардын Хувьсгалт намд иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандивын тайланг Аудитын дээд байгууллагуудын Олон улсын стандарт-4000, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/47 тоот тушаалаар

батлагдсан зааврыг баримтлан Улс төрийн намын тухай хуулийн 18 дугаар зүйлтэй нийцэж буй эсэхийг дэмжих нотлох баримт, дүн дүгнэлтийн үндсэн дээр хянан баталгаажуулж, дүгнэлт гаргасан болно.

### **Дүгнэлт**

Монгол Ардын Хувьсгалт нам ээлжит сонгуулийн жилийн 06 дугаар сарын 01-ний өдрөөс өмнөх жилийн 01 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэл хугацаанд хандив хүлээн аваагүй, хандивын орлого бүртгэгдэж тайлагнаагүй байна.

Монгол Ардын Хувьсгалт намаас ирүүлсэн хандивын тайланг хавсралтаар хүргүүлэв.

Хавсралт: ... хуудастай.

ДАРГА БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.ХУАНГАН

00402198